



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/82

Сүхбаатар сум

### Ажлын цагт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2, 23 дугаар зүйлийн 23.3, 32 дугаар зүйлийн 32.1.8, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ коронавирус /COVID-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 30-ны өдрийг дуустал хугацаанд жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эх / өрх талгойлсон эцэг/ ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангах, цалинтай чөлөө олгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн удирдлагуудад даалгасугай.

2. Төрийн албаны тасралтгүй байдлыг хангаж, албан үүргийг бүрэн гүйцэтгүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй явуулах, ажлын цаг ашиглалтыг үр бүтээлтэй хангаж, хэрэгжүүлсэн ажлын тайлангаа тухай бүр тайлагнаж ажиллахыг газар, хэлтэс, алба, сумдын Засаг дарга нарт даалгасугай

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ